



Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн
хуралдааны ~~дохионы~~ ~~21~~-дугаар сарын ~~23~~-
ны өдрийн ~~06~~ дугаар тогтоолын хавсралт

УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ /Шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журам нь улс төрийн намыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах болон татан буулгах, намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон намын даргыг томилсон шийдвэрийг бүртгэх, бүртгэлээс хасах, намыг идэвхтэйд, эсхүл идэвхгүйд тооцох (цаашид улс төрийн намын бүртгэл хөтлөх гэх), түүнчлэн намын нэрийн сан хөтлөх, тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох зэрэг үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Улс төрийн намын бүртгэл хөтлөхөд Улс төрийн намын тухай хууль (цаашид хуулийн гэх), Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1, 26.5, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны (цаашид Нийт шүүгчийн хуралдаан гэх) дэг болон энэ журмыг удирдлага болгоно.

- 1.3. Улс төрийн намын бүртгэл дараах төрөлтэй байна. Үүнд:
- 1.3.1. шинээр үүсгэн байгуулагдсан намын бүртгэл
 - 1.3.2. өөрчлөн байгуулагдсан намын бүртгэл
 - 1.3.3. намын үйл ажиллагааг зогсоосны бүртгэл
 - 1.3.4. нам тараасны бүртгэл
 - 1.3.5. намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл
 - 1.3.6. намын даргын бүртгэл
 - 1.3.7. намыг идэвхтэйд, эсхүл идэвхгүйд тооцох бүртгэл
- 1.4. Энэ журмын 1.3-т зааснаас бусад асуудлаар Улсын дээд шүүх бүртгэл хийхгүй.

Хоёр. Өргөдлийг хүлээн авч, хуваарилах, бэлтгэл ажиллагаа

2.1. Энэхүү журмын 1.3-т заасан бүртгэлтэй холбоотой өргөдлийг бичиг хэргийн ажилтан хүлээн авснаас хойш 1 хоногийн дотор Улс төрийн намын бүртгэлийн албанд зохих журмын дагуу шилжүүлнэ.

2.2. Өргөдлийг Улс төрийн намын бүртгэлийн алба (цаашид Бүртгэлийн алба гэх) хүлээн авч, өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудыг энэ журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу шалгаж, хуудасны тоог бүртгэлд тусган, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

2.3. Бүртгэлийн алба өргөдөл, хавсаргасан баримт бичиг бүрэн гүйцэд эсэхийг шалгаж, бүрдэл дутуу бол зөрчлийг арилгаж, нэмэлт баримт, мэдээлэл ирүүлэхийг хугацаа заан өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

2.4. Өргөдөл гаргагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуульд заасан хугацааг хэтрүүлэн өргөдөл гаргасан, заасан хугацаанд бүрдүүлбэр хангаж ирүүлээгүй бол Бүртгэлийн албаны танилцуулгыг үндэслэн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хурлаас өргөдлийг бусад баримтуудын хамт шүүгч албан бичгээр буцаана.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2.5.Өргөдөл нь баримт бичгийн бүрдэл хангасан бол Бүртгэлийн алба нь бүртгэлийн төрлөөс хамаарч энэхүү журамд заасан шалгах ажиллагааг хэрэгжүүлнэ. Хэрэв зөрчил илэрвэл зөрчлийг арилгаж, нэмэлт баримт мэдээлэл ирүүлэхийг өргөдөл гаргагчид хугацаа заан мэдэгдэнэ. Шаардлагатай гэж үзвэл сонсох ажиллагаа явуулж болно.

2.6.Өргөдөл гаргагч заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй бол Захиргааны хэргийн танхимиын нийт шүүгчийн хурлаар хэлэлцэж өргөдлийг холбогдох баримтын хамт шүүгч буцаана.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2.7.Өргөдөл бүрдэл хангасан бөгөөд зөрчилгүй гэж үзвэл өргөдөл, холбогдох баримтыг Бүртгэлийн алба Захиргааны хэргийн танхимд шилжүүлэх ба танхимиын тэргүүний туслах тогтоосон дарааллын дагуу өргөдлийг шүүгчид хуваарилна.

2.8.Хүлээн авсан шүүгч танилцуулга бэлдэж, танхимиын нийт шүүгчийн хуралд танилцуулах ба Танхимиын тэргүүн танилцуулгыг Ерөнхий шүүгчид хүргүүлнэ. Ерөнхий шүүгч хуульд заасан хугацаанд багтаан Нийт шүүгчийн хуралдааныг зарлан хуралдуулна.

2.9.Тухайн намын бүртгэлтэй холбоотой хэд хэдэн өргөдөл ирсэн бол агуулгаас хамаарч нэгтгэн хэлэлцэж болно. Өргөдлийн нэгтгэн хэлэлцэх эсэхийг Захиргааны хэргийн танхимиын нийт шүүгчийн хурлаар шийдвэрлэнэ.

2.10.Журмын 2.6-д заасан үндэслэлээр буцаасан, Нийт шүүгчийн хуралдаанаас зөрчилтэй гэж үзсэн асуудлаар тухайн зөрчлөө арилгалгүй дахин гаргасан өргөдлийг Захиргааны хэргийн танхимиын нийт шүүгчийн хурлаар хэлэлцэж шүүгч албан бичгээр хариу өгч буцаана.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

2.11.Өргөдөл гаргагч зөрчлөө арилган Бүртгэлийн албандаа хандсан үеэс эхэлж хуульд заасан хугацааг тоолно.

Гурав.Шинээр үүсгэн байгуулагдсан намын бүртгэл

3.1.Шинээр үүсгэн байгуулагдсан нам нь Улсын дээд шүүхэд бүртгүүлэхдээ Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан мэдээлэл бүхий өргөдөл болон 12.3-т заасан баримт бичгийг дараах байдлаар бүрдүүлнэ:

3.1.1.намыг үүсгэн байгуулах их хурлаас сонгогдсон намын дарга, эсхүл тухайн хурлаас томилогдсон эрх бүхий этгээд (итгэмжлэгдсэн төлөөлөгч) намыг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл (Хавсралт №1, 1А-д заасан маягтын дагуу) гаргаж, гарын үсэг зурсан байна.

3.1.2.өргөдөлд хуулийн 12.3-т заасан баримт бичгээс гадна нам үүсгэн байгуулах хурал зохион байгуулах газар, хугацааг 1 сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн болохыг нотолсон баримт, хуралд оролцсон орон нутгийн төлөөлөгчдийн талаарх мэдээллийг ирүүлнэ.

3.1.3.гишүүдийн бүртгэлд намд элсэх өдөр хуанлийн тооллоор 18 насанд хүрсэн, өөр намын харьяалалгүй болон бусдаар төлөөлүүлж намд элсээгүй тухай нотломжийг хавсаргана. Намын 801-н гишүүдийн бүртгэл, өөр намын харьяалалгүй тухай нотломж, бусдаар төлөөлүүлж намд элсээгүй тухай нотломжид бичигдсэн намын гишүүдийн бүртгэлийн дугаар нэг байна. Гишүүдийн мэдээллийг цаасаар болон MSWord doc өргөтгөлөөр ирүүлнэ.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

3.1.4.гишүүний тоо нь 801-ээс бага байх тохиолдолд шаардлага хангагүй өргөдөл тооцно. Харин их тохиолдолд илүү гишүүний мэдээллийг өргөдөл гаргагчид өөрийнх нь сонголтоор буцаана. 801 гишүүний бүртгэлд байгаа намын гишүүн нь иргэний улсын бүртгэлд бүртгэгдсэнээс өөр хаягт түр оршин сууж байгаа болон хаягийн бүртгэл зөрүүтэй нөхцөл байгаа бол уг мэдээлэл, холбогдох баримтыг хавсаргана.

3.1.5.намын хөрөнгийн мэдээлэлд намыг бүртгүүлэх өргөдөл гаргахаас өмнө тухайн намын аль нэг үүсгэн байгуулагчийн нэр дээр банкны түр данс нээж намын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, гишүүний татвар, хандив, намыг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг тусгаж тайлагнасан байна.

3.1.6.намын нэр, бэлгэдэл, далбааны зургийн утга учрыг тайлбарласан байвал зохино.

3.2.Нам үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг холбогдох баримт бичгийг хавсарган гаргах бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас уг хугацааг хэтрүүлсэн тохиолдолд тухайн шалтгаанаа нотолсон баримтын хамт хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлж болно.

3.3.Өргөдөл бүрдүүлбэрийн шаардлага хангасан, өргөдөл гаргагч заасан хугацаанд нэмэлт баримт мэдээлэл ирүүлсэн бол Бүртгэлийн алба шүүгчид танилцуулж 21 хоногийн дотор дараах асуудлыг нягтлан шалгана. Үүнд:

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

3.3.1.намын дүрэм, мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэх;

3.3.2.намын гишүүдийн тоо хуулиар тогтоосон хэмжээнд хүрсэн эсэх;

3.3.3.гишүүдийн бүртгэл үнэн зөв эсэх;

3.3.4.бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьялалтай эсэх;

3.3.5.өөр хүнээр төлөөлүүлж намд элссэн эсэх;

3.3.6.хуульд заасан хугацааны дотор нам үүсгэн байгуулах хурлын товыг төлөөлөгчдөд мэдэгдсэн эсэх;

3.3.7.нам үүсгэн байгуулах хуралд орон нутгаас төлөөлөгчид оролцуулсан эсэх;

3.3.8.намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэдэл, далбаа нь давхардсан эсэх, бусдыг төөрөгдүүлэхээр эсэх.

3.4.Дээрх шаардлагыг зөрчсөн бол Бүртгэлийн алба энэ журмын 2.5-д заасан ажиллагааг 30 хоногийн дотор явуулна.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

3.5.Өргөдөл гаргагч заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй бол журмын 2.6-д зааснаар буцаана.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

3.6.Бүртгэлийн албанаас шилжүүлсэн өргөдлийг хүлээн авсан шүүгч 7 хоногийн дотор танхимын хуралд танилцуулах ба Танхимын тэргүүн танилцуулгыг Ерөнхий шүүгчид хүргүүлнэ. Ерөнхий шүүгч танилцуулгыг хүлээн авснаас хойш 23 хоног (өргөдлийг Бүртгэлийн албанаас шилжүүлснээс хойш 30)-ийн дотор Нийт шүүгчийн хуралдааныг зарлан хуралдуулна.

Дөрөв.Өөрчлөн байгуулагдсан намын бүртгэл

4.1. Нам нь хуульд заасны дагуу нийлэх, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд энэ тухай шийдвэрийг намын удирдах дээд байгууллага гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

4.2. Хоёр буюу түүнээс дээш нам үйл ажиллагаагаа зогсоож, нийлсэн тохиолдолд үйл ажиллагаагаа зогсоосон намуудын дарга, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч болон өөрчлөн байгуулагдсан намын дарга, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч үйл ажиллагаагаа зогсоосон намыг бүртгэлээс хасаж, шинээр байгуулагдсан намыг бүртгүүлэх өргөдлийг энэ журмын Хавсралт №2, 2А-д заасан баримт бичгийн хамт гаргана.

4.3. Намууд нэгдсэн тохиолдолд үйл ажиллагаагаа зогсоож буй намын дарга, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нэгдэн орж буй намыг бүртгэлээс хасаж, өөр намд нэгдэн орох тухай хүсэлт болон нэгтгэж буй намын дарга, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч намыг нэгтэн авах тухай хүсэлтийг Хавсралт №3, 3А-д заасан баримт бичгийн хамт гаргана.

4.4. Хүсэлтийг хянан хэлэлцэж, шийдвэрлэхэд журмын 3.3-3.6-д заасан хугацаа үйлчилнэ.

Тав. Үйл ажиллагаагаа зогсоосон болон тараасан намын бүртгэл

5.1. Намын үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэрийг намын удирдах дээд байгууллага гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор тухайн намын дарга, эсхүл намын удирдах дээд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч намыг татан буулгах өргөдлийг Улсын дээд шүүхэд журмын Хавсралт №4, 4А-д заасан бүрдлийг хангаж ирүүлнэ.

5.2. Өргөдлийг хянан хэлэлцэж, шийдвэрлэхэд журмын 3.6-д заасан хугацаа үйлчилнэ.

5.3. Сонгуулийн төв байгууллагаас намыг тараах тухай саналыг Улсын дээд шүүхэд хүргүүлэхдээ тухайн нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3-т заасан хориглолтыг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн талаарх холбогдох баримт болон тухайн асуудлыг хэлэлцсэн тус байгууллагын хурлын тэмдэглэл зэргийг хавсаргана.

5.4. Сонгуулийн төв байгууллагын гаргасан саналыг тогтоосон дарааллын дагуу шүүгчид хуваарилж, хүлээн авсан шүүгч 5 хоногийн дотор танхимиын нийт шүүгчийн хуралд танилцуулна. Танхимиын тэргүүн саналыг Ерөнхий шүүгчид хүргүүлснээс хойш 25 хоног (Сонгуулийн төв байгууллагын саналыг УДШ хүлээн авснаас хойш 30 хоног)-ийн дотор Ерөнхий шүүгч Нийт шүүгчийн хуралдааныг зарлан хуралдуулна.

5.5. Журмын 5.4-ийн дагуу Сонгуулийн төв байгууллагын саналыг хүлээн авсан шүүгч шаардлагатай гэж үзвэл 2.5-д заасан ажиллагааны хүрээнд холбогдох намаас тайлбар, баримтыг гаргуулж болно.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоогоор өөрчилсөн/

Зургаа. Намын дүрэмд оруулсан өөрчлөлт болон намын даргыг томилсон
шийдвэрийн бүртгэл

6.1. Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухайн шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор намын дарга, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч журмын Хавсралт №5, 5А-д заасан бүрдлийг хангаж Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

6.2. Өргөдөлд өөрчлөлт орохоос өмнөх намын дүрэм болон өөрчлөлт оруулсан дүрмийн хувийг цаасаар болон MSWord doc өргөтгөлөөр тус тус хавсаргана.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

6.3.Хэрэв намын төлөөллийн төв байгууллага дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол тус байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргасныг, түүнчлэн оруулсан нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байх шаардлагыг хангасан талаарх нотлох баримтыг өргөдөлд хавсаргана.

6.4.Намын даргыг томилсон шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор тухайн намын өмнөх дарга, эсхүл намын даргыг сонгох эрх бүхий удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч шинээр томилогдсон даргыг бүртгүүлэх тухай хүсэлтийг журмын Хавсралт №6, 6А-д заасан бүрдлийг хангаж Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

6.5.Хүсэлтийг хүлээн авсан Бүртгэлийн алба журмын 2.5-д заасан ажиллагааг 10 хоногийн дотор хэрэгжүүлнэ. Хэрэв зөрчил илэрсэн бол зөрчлийг арилгуулахаар боломжит хугацаа заан өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

6.6.Шүүгч журмын 6.5-д заасан хугацаа дууссанаас хойш 5 хоногийн дотор танхимын нийт шүүгчийн хуралд танилцуулж, Танхимын тэргүүн танилцуулгыг Ерөнхий шүүгчид хүргүүлнэ. Ерөнхий шүүгч танилцуулгыг хүлээн авснаас хойш 15 хоног (Бүртгэлийн алба хүсэлтийг хүлээн авсан, эсхүл өргөдөл гаргагч зөрчлөө арилгаснаас хойш 30 хоног)-ийн дотор Нийт шүүгчийн хуралдааныг зарлан хуралдуулна.

Долоо.Намыг идэвхгүйд/идэвхтэйд тооцох

7.1.Сонгуулийн төв байгууллагаас намыг идэвхгүйд тооцох тухай мэдээллийг Улсын дээд шүүхэд ирүүлэхдээ дараах үндэслэлийн аль нэг нь эсхүл хэд нь бүрдсэн талаарх нотлох баримтыг хавсаргана. Үүнд:

7.1.1.тухайн нам УИХ-ын ээлжит сонгуульд хоёр удаа дараалан нэр дэвшүүлэн оролцоогүй;

7.1.2.хоёр жил дараалан санхүүгийн тайлан ирүүлээгүй;

7.1.3.намын удирдах дээд байгууллагыг эсхүл төлөөллийн төв байгууллагыг таван жилийн хугацаанд хуралдуулаагүй.

7.2.Намын эрх бүхий байгууллага зөрчлөө арилгасан бол Сонгуулийн төв байгууллага холбогдох баримтыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

7.3.Сонгуулийн төв байгууллагын мэдээллийг дарааллын дагуу шүүгчид хуваарилж, хүлээн авсан шүүгч 20 хоногийн дотор хянаж, танхимын нийт шүүгчийн хуралд танилцуулна. Танхимын тэргүүн саналыг Ерөнхий шүүгчид хүргүүлэх ба Ерөнхий шүүгч саналыг хүлээн авснаас хойш 40 хоног (Сонгуулийн төв байгууллагын мэдээлэл УДШ-д ирснээс хойш 60 хоног)-ийн дотор Нийт шүүгчийн хуралдааныг зарлан хуралдуулна.

7.4.Хэрэв шүүгч шаардлагатай гэж үзвэл журмын 2.6-д заасан ажиллагааны хүрээнд холбогдох намаас тайлбар, баримт авч болох бөгөөд хуульд заасан (60 хоног) хугацаанд багтаах байдлаар тооцно.

Найм.Өргөдлийг Улсын дээд шүүхийн
нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх

8.1. Ерөнхий шүүгч Нийт шүүгчийн хуралдааныг товлосон бол хэлэлцэх асуудлыг шүүгч наарт гурваас доошгүй хоногийн өмнө мэдэгдэж, холбогдох баримтуудыг хүргүүлж, энэ тухай Улсын дээд шүүхийн мэдээллийн цахим хуудсанд байршуулна.

8.2. Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой өргөдлийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д зааснаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд энэ журамд өөрөөр зааснаас бусад тохиолдолд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны дэгийг баримтална.

8.3. Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой асуудлыг хэлэлцэх ажиллагаа өргөдлийг хүлээн авсан шүүгчийн илтгэлээр эхэлж, илтгэгч шүүгч Улсын дээд шүүхэд ирүүлсэн өргөдлийн агуулга, баримт бичгийн бүрдэл, хуралдааны бэлтгэл хангах хугацаанд явуулсан үйл ажиллагаа зэргийг танилцуулна.

8.4. Өргөдлийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т зааснаар нийт шүүгчийн олонхын саналаар шийдвэрлэх ба шийдвэрийг Улсын дээд шүүхийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлнэ.

8.5. Улс төрийн намын тухай хуульд Улсын дээд шүүхийн шийдвэрийг бусад байгууллагад хүргүүлэхээр заасан бол холбогдох журмын дагуу Тамгын газар хэрэгжүүлнэ.

8.6. Бүртгэл хийхээс татгалзах хуульд заасан үндэслэл байгаа бол, түүнчлэн өргөдлийг хэлэлцэх явцад Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан намын хяналтын байгууллагын шийдвэрлэх дотоод маргаан болох нь тогтоогдвол бүртгэхээс татгалзаж, өргөдлийг буцаана.

8.7. Өргөдлийг буцааж, бүртгэхээс татгалзсан нь өргөдөл гаргагчийн зөрчлөө арилган дахин хандах эрхийг хязгаарлахгүй.

8.8. Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үндэслэл тогтоогдвол шүүгч татгалзан гарна. Мөн үндэслэлээр шүүгч өөрөө, эсхүл шүүгчээс татгалзсан бол Нийт шүүгчийн хуралдаанаар тус тус шийдвэрлэнэ.

Ес. Намын нэрийн сан хөтлөх

9.1. Дараах тохиолдолд улс төрийн намын нэр авах хүсэлтийг Бүртгэлийн албанд гаргаж, тухайн нэрийн баталгаажуулалт хийлгэнэ:

9.1.1. намыг шинээр байгуулах;

9.1.2. намын нэрийг өөрчлөх.

9.2. Хүсэлтэд дурдсан нэр нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй бусад намын нэр болон өөр бусад хуулийн этгээдийн нэртэй давхцаагүй бол нэрийн баталгаажилт хийнэ. Хэрэв нэр давхацсан бол Бүртгэлийн алба нэрийн баталгаажилт хийхгүй бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлыг Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хурал шийдвэрлэнэ.

9.3. Энэ журамд заасны дагуу баталгаажсан намын нэр 30 хоногийн дотор хүчинтэй байна. Өргөдөл гаргагчийн хүсэлтээр уг хугацааг 60 хоногоор сунгаж болно. (Хавсралт №7)

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

9.4. Энэ журмын 3.2-т заасан хугацаанд намыг бүртгүүлэх өргөдлийг Улсын дээд шүүхэд гаргаагүй тохиолдолд тухайн нэрийн баталгаажуулалт хүчингүй болох бөгөөд намын нэр баталгаажуулах хүсэлтийг энэ журамд заасны дагуу дахин гаргаж болно.

Арав. Намын тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох

10.1.Хяналтын дугаар шинээр олгох болон дахин олгох, олгогдсон хяналтын дугаар, тамга, хүчингүй болгох, хураалгасан тамга, устгах, лавлагаа олгох үйл ажиллагааг Бүртгэлийн алба хэрэгжүүлнэ.

10.2.Нам шинээр үүсгэн байгуулагдсан болон намууд нийлж нэг нам болсныг улсын бүртгэлд бүртгэх тухай Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол гарснаар тухайн намд тамганы хяналтын дугаарыг шинээр олгоно.

10.3.Нам нийлсэн тохиолдолд шинээр тамганы хяналтын дугаарыг олгоно, нам нэгдсэн тохиолдолд нэгдэн орж буй намын тамганы хяналтын дугаарыг үргэлжлүүлэн хэрэглэнэ. Нэгдсэн намын нэр өөрчлөгдсөн нь тамганы хяналтын дугаарыг өөрчлөх үндэслэл болохгүй.

10.4.Нэг намд нэг тамганы хяналтын дугаар олгох бөгөөд уг дугаарыг намын дотоод зохион байгуулалтын салбар нэгжийн тамга, тэмдэгт ашиглаж болно.

10.5.Хяналтын дугаар өөрчлөх, эсхүл дахин авах хүсэлтэд намын эрх бүхий этгээдийн шийдвэр болон холбогдох баримтуудыг хавсаргах ба эрх бүхий этгээд (Хавсралт №8, 8А)-д заасан баримтыг хавсаргана.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

10.6.Бүртгэлийн алба тамга тэмдгийн хяналтын дугаар болон гэрчилгээ авах өргөдлийг Захиргааны хэргийн танхимиын нийт шүүгчийн хуралд танилцуулснаар дахин олгох эсэхийг шийдвэрлэнэ.

10.7.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээд Улсын дээд шүүхээс олгосон хяналтын дугаарыг үндэслэн улс төрийн намын тамга, тэмдэг үйлдвэрлэсэн тайланг улирал бүрийн сүүлийн сарын 30-ны өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор Улсын дээд шүүхэд ирүүлэх бөгөөд тайланд үйлдвэрийн албан бичиг, үйлдвэрлэсэн тамга, тэмдгийн жагсаалтыг хавсаргана. (Хавсралт №9)

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

10.8.Нам татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан үндэслэлээр улсын бүртгэлээс хасагдсан бол тамга, тэмдгээ хураалгана.

10.9.Бүртгэлийн алба хураалгасан тамга, тэмдгийг хадгалалт, хамгаалалт, устгах ажлыг жил бүр ажлын хэсэг гарган зохион байгуулна.

Арван нэг.Улсын дээд шүүхэд улс төрийн намын бүртгэл хөтлөхтэй холбоотой баримт бичгийг хадгалах болон бусад асуудал

11.1.Улс төрийн намыг бүртгүүлэх тухай өргөдөл, түүнд хавсаргасан бичгийн болон цахим хэлбэрийн баримтыг зохих бүртгэлд тусгаж, улс төрийн намыг улсын бүртгэлд бүртгэсэн тохиолдолд тухайн намын хувийн хэргийг нээж, дээрх баримт, шүүхийн тогтоол болон бусад баримтыг хуудас тус бүрээр товьёглон бичгээр болон цахим хэлбэрээр хадгална.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

11.2.Улс төрийн намын бүртгэл хийхээс татгалзсан тохиолдолд хүсэлт болон түүнд хавсарган ирүүлсэн баримтуудыг хуулбарлац авч үлдэн (намын хувийн хэрэгт хавсаргалгүйгээр тусад нь татгалзсан бүртгэлийн хавтас үүсгэн), жагсаалтаар өргөдөл гаргагчид буцаан өгч, бичиг баримтыг хүлээлгэн өгсөн тухай гарын үсэг бүхий тодорхойлолтыг цахим бүртгэлд үлдэх баримтад шилжүүлэн хадгална.

11.3. Улс төрийн намын улсын бүртгэлд бүртгэлтэй намын дүрэм, мөрийн хөтөлбөрт өөрчлөлт орсон, нам нэрээ өөрчилж, эсхүл өөрчлөн байгуулагдсан тухай өргөдөл, түүнд хавсаргасан бичгийн болон цахим хэлбэрийн баримтуудыг зохих бүртгэлд тусгаж, өргөдлийг хангасан эсэхээс үл хамааран эдгээр болон шүүхийн ажиллагааг тусгасан бусад баримт, эрхийн актыг тухайн намын хувийн хэрэгт хуудас тус бүрээр товьёглон, мөн цахим хэлбэрээр тус тус хадгална.

11.4. Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой баримтуудын эхийг өргөдөл гаргасан этгээд хүсвэл буцаан өгч болно. Харин уг баримтын нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар болон хүсэлт, баримтыг хүлээлгэн өгсөн тодорхойлолтын хамт хадгална.

11.5. Намыг шинээр болон өөрчлөн байгуулагдах замаар бүртгэсэн тохиолдолд Бүртгэлийн алба улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга тэмдгийн хяналтын дугаар олгож, холбогдох мэдээллийг хуулийн 14.3-д заасны дагуу нийтэд ил тод байршуулна. Улсын бүртгэлийн гэрчилгээ олгоход улсын тэмдэгтийн хураамж 300 000 төгрөг төлнө.

11.6. Нийт шүүгчийн хуралдаанаас Улс төрийн намын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 буюу энэ журмын 4, 5-д заасан өргөдөл, саналыг хэлэлцэн намыг татан буулгасан бол Бүртгэлийн алба тухайн намыг улсын бүртгэлээс хасаж, гэрчилгээ, тамга тэмдгийг хүчингүй болгоно.

11.7. Намын улсын бүртгэлийн гэрчилгээ ашиглах боломжгүйгээр элэгдэж хуучирсан, гэмтсэн, устсан, хаяж үрэгдүүлсэн бол гэрчилгээг дахин авах өргөдөл гаргах бөгөөд түүнд өдөр тутмын сонин, олон нийтийн сүлжээнд зарлуулсан зар, үйлчилгээний хөлс төлсөн баримтыг хавсаргана. Гэрчилгээ дахин олгох эсэхийг Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд хүсэлтийг хангасан тохиолдолд гэрчилгээг дахин олгоход тэмдэгтийн хураамж төлнө.

11.8. Улс төрийн намын бүртгэлийн талаар лавлагаа авах, намын хувийн хэргээс бичиг баримт хуулбарлах, намын хувийн хэрэгтэй танилцах зэрэг асуудлаар гаргасан хүсэлтийг Захиргааны хэргийн танхимын тэргүүн болон Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргад танилцуулснаар Бүртгэлийн алба хэрэгжүүлнэ.

11.9. Улс төрийн намын бүртгэл хөтлөхтэй холбоотой өргөдөл гаргасан болон бусад этгээдээс тайлбар, мэдээлэл авах зорилгоор Бүртгэлийн алба сонсох ажиллагааг хийхдээ Захиргааны ерөнхий хуулийн 27-28 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

11.10. Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, хүсэлт, түүний агуулгыг Улсын дээд шүүхийн цахим хуудаст тухай бүр мэдээлнэ.

11.11. Улс төрийн намын бүртгэлд үг, үсэг, тоо зэрэг техникийн шинжтэй өөрчлөлт оруулах тухай өргөдлийг Бүртгэлийн алба Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

11.12. Нам өөрийн оршин байгаа газрын хаяг, хөрөнгө, түүний өөрчлөлттэй холбоотой бүртгэлийг холбогдох шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор (Хавсралт №10, 10A, 11, 11A)-д заасан баримтыг бүрдүүлж, Улсын дээд шүүхэд бүртгүүлнэ. Бүртгэлийн алба өргөдлийг шалгаж, зохих өөрчлөлтийг хийнэ.

/Энэ хэсгийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор өөрчилсөн/

11.13. Энэ журмын биелэлтэд Захиргааны хэргийн танхимын тэргүүн, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга нар хамаарах чиг үүргийн хүрээнд тус тус хяналт тавина.

Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №1

НАМ ҮҮСГЭН БАЙГУУЛСНЫГ УЛСЫН
БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ



1. Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--

2. Намын бүтэн болон товчилсон нэр:

3. Намыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл:

4. Өргөдөл гаргагчийн мэдээлэл:

Овог:

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:

Регистрийн дугаар:

Утасны дугаар:

Намд эрхэлж буй ажил:

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №1А

НАМ ҮҮСГЭН БАЙГУУЛСНЫГ УЛСЫН БҮРТГЭЛД
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТ

1.Өргөдөл:

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

3.Намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн мэдээлэл.

(овог, нэр, албан тушаал, иргэний үнэмлэхийн хуулбар, итгэмжлэл)

Хүсэлтэд хавсаргах баримт бичгийн жагсаалт:

4.Намыг үүсгэн байгуулах тогтоол, шийдвэр, хурлын тэмдэглэл

5.Нам үүсгэн байгуулах хурлын товыг 2 сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн баримт

6.Их хуралд ирсэн төлөөлөгчдийн бүртгэл, (ургийн овог, эцгийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, ирцийн бүртгэл, утасны дугаар, гарын үсэг, цахимаар хурал зохион байгуулсан бол ирцийн бүртгэл, хурлын явц болон санал хураалтын дүнг баталгаажуулсан видео бичлэг, фото зураг зэрэг холбогдох бусад баримт)

7.Намыг үүсгэн байгуулах хуралд оролцсон орон нутгийн төлөөлөгчдийн бүртгэл, оролцуулсан тухай баримт (ургийн овог, эцгийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, аль аймгийн төлөөлөл болох, гишүүдийн бүртгэлийн хэдэд бүртгэгдсэн болох, ирцийн бүртгэл, утасны дугаар, гарын үсэг, цахимаар хурал зохион байгуулсан бол ирцийн бүртгэл, санал хураалтын дүнг баталгаажуулсан холбогдох бусад видео бичлэг, фото зураг зэрэг холбогдох бусад баримт)

8.Намын бэлгэдэл, далбаа (тэдгээрийн тайлбар)

9.Намын дүрэм


10.Намын мөрийн хөтөлбөр

11.Намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа хууль ёсны хаяг (аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хороолол, гудамж, байшин, хашаа, хаалганы дугаар, утасны дугаар, цахим хаяг)-ыг нотолсон засаг захиргааны тодорхойлолт

12. Намын 801-н гишүүдийн тоо, бүртгэл (цаасаар, MSWord doc өргөтгөлөөр, бүртгэлд; ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, түр оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг)
13. Намын санхүүгийн асуудал эрхэлсэн эрх бүхий удирдах ажилтан (менежер, ерөнхий нягтлан бодох)-ын бүртгэл (ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин сугаа газрын хаяг, гарын үсэг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, иргэний үнэмлэхийн хуулбар, төрийн алба, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд давхар албан хашдаггүй тухай баримт)
14. Намын хөрөнгийн мэдээлэл (үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн жагсаалт, мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, гишүүний татвар, хандивын жагсаалт, намыг үүсгэн байгуулахтай холбоотой зардал, тухайн намыг үүсгэн байгуулж буй удирдах албан тушаалтны нэр дээр түр данс нээсэн бол түүнийг тусгана)
15. Нам үүсгэн байгуулах хурал зохион байгуулах газар, хугацааг 1 сарын өмнө мэдэгдэж, зарласан тухай баримт
16. Намын гишүүний өөр намын гишүүн биш болохыг баталсан нотломж, (овог нэр, регистрийн дугаар, өөр намын гишүүн эсэх, гарын үсэг, гишүүний бүртгэлийн хэдэд бүртгэгдсэн болох)
17. Намын гишүүнд элсэхдээ бусдаар төлөөлүүлээгүй тухай нотломж, (овог нэр, регистрийн дугаар, өөр хүнээр төлөөлүүлж намд элссэн эсэх, гарын үсэг, гишүүний бүртгэлийн хэдэд бүртгэгдсэн болох)

Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №2

НАМ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛСНЫГ (НИЙЛЭХ ЗАМААР) УЛСЫН
БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ



1. Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--	--

2. Шинээр үүсгэн байгуулагдсан намын
бүтэн болон товчилсон нэр:

--

3. Намыг өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

4. Өргөдөл гаргагчийн мэдээлэл:

Овог:

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:

Регистрийн дугаар:

Утасны дугаар:

Намд эрхэлж буй ажил:

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

НАМ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛСНЫГ (НИЙЛЭХ ЗАМААР) УЛСЫН
БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТ

1. Өргөдөл:

2. Шинээр байгуулагдсан намын бүтэн болон товчилсон нэр:

3. Намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн мэдээлэл.
(овог, нэр, албан тушаал, иргэний үнэмлэхийн хуулбар, итгэмжлэл)

Хүсэлтэд хавсаргах баримт бичгүүд:

4. Үйл ажиллагаагаа зогсоож, нийлэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн намуудын Их Хурлын шийдвэр, тэмдэглэл, холбогдох баримт (цахимаар хуралдсан бол хурлын явцыг баталгаажуулсан видео бичлэг, фото зураг зэрэг холбогдох бусад баримт)

5. Намын бэлгэдэл, далбаа (тэдгээрийн тайлбар)

6. Намын дүрэм

7. Намын мөрийн хөтөлбөр

8. Намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа хууль ёсны хаяг (аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хороолол, гудамж, байшин, хашаа, хаалганы дугаар, утасны дугаар, цахим хаяг)-ыг нотолсон засаг захиргааны тодорхойлолт/

9. Намын гишүүдийн тоо, бүртгэл, хурлын тэмдэглэл (ургийн овог, эцгийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, иргэний үнэмлэхэд бичигдсэн оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, гарын үсэг)


10. Намын санхүүгийн асуудал эрхэлсэн эрх бүхий удирдах ажилтан (менежер, ерөнхий нягтлан бодох)-ын бүртгэл (овог, эцгийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг, утасны дугаар, боловсролын гэрчилгээ)

11. Намын өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгийн мэдээ (үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн жагсаалт, тус намын гишүүн, дэмжигч иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын жагсаалт, тухайн намыг үүсгэн байгуулж буй удирдах албан тушаалтны нэр дээр түр данс нээсэн бол түүнийг тусгана)

12. Өөрчлөн байгуулагдах замаар үйл ажиллагаагаа зогсоож буй намын гэрчилгээ, эд хөрөнгийг шилжүүлсэн тухай холбогдох байгууллагын мэдээлэл

Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №3

**НАМ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛСНЫГ (НЭГДЭХ ЗАМААР) УЛСЫН
БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**



1.Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--

2.Нэгтгэж буй намын бүтэн болон
товчилсон нэр:

3.Намыг өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

4.Өргөдөл гаргагчийн мэдээлэл:

Овог:

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:

Регистрийн дугаар:

Утасны дугаар:

Намд эрхэлж буй ажил:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

НАМ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛСНЫГ (НЭГДЭХ ЗАМААР) УЛСЫН
БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТ

1.Өргөдөл:

2.Нэгтгэж буй намын бүтэн болон товчилсон нэр:

3.Намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн мэдээлэл
(овог, нэр, албан тушаал, иргэний үнэмлэхийн хуулбар, итгэмжлэл)

Хүсэлтэд хавсаргах баримт бичгүүд:

4.Үйл ажиллагаагаа зогсоож, өөр намд нэгдэх тухай асуудлыг шийдвэрлэсэн
намын Их Хурлын шийдвэр, тэмдэглэл, холбогдох баримт (цахимаар
хуралдсан бол хурлын явцыг баталгаажуулсан видео бичлэг, фото зураг зэрэг
холбогдох бусад баримт)

5.Өөр намыг нэгтгэн авах тухай асуудлыг шийдвэрлэсэн намын Их Хурлын
шийдвэр, тэмдэглэл, холбогдох баримт (цахимаар хуралдсан бол хурлын
явцыг баталгаажуулсан видео бичлэг, фото зураг зэрэг холбогдох бусад
баримт)

6.Намын гишүүдийн тоо, бүртгэл (ургийн овог, эцгийн болон өөрийн нэр,
регистрийн дугаар, иргэний үнэмлэхэд бичигдсэн оршин суугаа газрын хаяг,
утасны дугаар, гарын үсэг)

7.Намын өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгийн
мэдээ (үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн жагсаалт, тус намын гишүүн,
дэмжигч иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын жагсаалт, тухайн намыг
үүсгэн байгуулж буй удирдах албан тушаалтны нэр дээр түр данс нээсэн бол
түүнийг тусгана)

8.Өөрчлөн байгуулагдах замаар үйл ажиллагаагаа зогсоож буй намын
гэрчилгээ, эд хөрөнгийг шилжүүлсэн тухай холбогдох байгууллагын мэдээлэл

НАМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООСНЫГ УЛСЫН БҮРТГЭЛД
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

1.Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

--

3.Намын үйл ажиллагааг зогсоосныг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

4.Өргөдөл гаргагчийн мэдээлэл:

Овог:

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:

Регистрийн дугаар:

Утасны дугаар:

Намд эрхэлж буй ажил:

НАМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООСНЫГ УЛСЫН БҮРТГЭЛД
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТ

1.Өргөдөл гаргасан он, сар өдөр:

<input type="text"/>							
----------------------	----------------------	----------------------	----------------------	----------------------	----------------------	----------------------	----------------------

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

3.Тухайн намын дарга, эсхүл намын удирдах дээд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн итгэмжлэл

4.Үйл ажиллагаагаа зогсоох тухай намын Их Хурлын шийдвэр, хурлын тэмдэглэл

5.Үйл ажиллагаа зогсоосон үндэслэл шалтгаан, намын дүрэмд заасан журмаар хэлэлцэгдсэн эсэхийг нотлох холбогдох баримт

6.Хуралд оролцсон гишүүдийн бүртгэл, утасны дугаар, хурлыг цахимаар хийсэн бол явцыг баталгаажуулсан видео бичлэг, фото зураг зэрэг холбогдох бусад баримт, санал хураалтын дүнг баталгаажуулсан баримт

7.Өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа

8.Үйл ажиллагааг зогсоох, тараах тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар

9.Улсын бүртгэлийн гэрчилгээ (эх хувь)

Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №5

НАМЫН ДҮРЭМД ОРУУЛСАН
ӨӨРЧЛӨЛТИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

1. Өргөдөл гаргасан он, сар өдөр:

<input type="text"/>							
----------------------	----------------------	----------------------	----------------------	----------------------	----------------------	----------------------	----------------------

2. Намын бүтэн болон товчилсон нэр:

3. Намын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай
өргөдөл:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

4. Өргөдөл гаргагчийн мэдээлэл:

Овог:	<input type="text"/>
Эцэг /эх/-ийн нэр:	<input type="text"/>
Өөрийн нэр:	<input type="text"/>
Регистрийн дугаар:	<input type="text"/>
Утасны дугаар:	<input type="text"/>
Намд эрхэлж буй ажил:	<input type="text"/>

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

НАМЫН ДҮРЭМД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТ

1.Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--	--	--

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

3.Намын дарга эсхүл түүнээс олгосон итгэмжлэл

4.Өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл

5.Дүрэмд өөрчлөлт оруулах болсон үндэслэл шалтгаан, холбогдох баримт

6.Өөрчлөлт оруулсан шийдвэр, хурлын тэмдэглэл

7.Хурлын ирц намын дүрэмд заасан шаардлагад хүрснийг нотлох баримт

8.Хуралд оролцсон гишүүдийн бүртгэл, утасны дугаар, хурлыг цахимаар хийсэн бол хурлын явцыг баталгаажуулсан видео бичлэг, фото зураг зэрэг бусад баримт, санал хураалтын дүнг баталгаажуулсан баримт

9.Өөрчлөлт орохоос өмнөх болон өөрчлөлт орсны дараах намын дүрэм

10.Намын нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт, өдөр тутмын сонинд зарлуулсан зар

11.Улсын бүртгэлийн гэрчилгээ (эх хувь)

тийм	үгүй
------	------

12.Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлэх эсэх

тийм	үгүй
------	------

13.Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №6

НАМЫН ДАРГЫГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

1.Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--	--

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

--

3.Намын дарга өөрчлөгдсөнийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

4.Өргөдөл гаргагчийн мэдээлэл:

Овог:

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:

Регистрийн дугаар:

Утасны дугаар:

Намд эрхэлж буй ажил:

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №6А

НАМЫН ДАРГЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТ

1.Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--	--	--

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

3.Тухайн намын өмнөх дарга, эсхүл намын даргыг сонгох эрх бүхий удирдах
дээд байгууллага юмуу төлөөллийн төв байгууллагын итгэмжлэгдсэн
төлөөлөгчийн аль нь болохыг нотлох баримт (итгэмжлэл)

4.Өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл

5.Дарга өөрчлөгдөх болсон үндэслэл шалтгаан, холбогдох баримт

6.Өөрчлөлт оруулсан шийдвэр, хурлын тэмдэглэл

7.Хурлын ирц намын дүрэмд заасан шаардлагад хүрсэн талаарх баримт

8.Хуралд оролцсон гишүүдийн бүртгэл, утасны дугаар, хурлыг цахимаар
хийсэн бол хурлын явцыг баталгаажуулсан баримт, санал хураалтын
дүнг баталгаажуулсан баримт, холбогдох бусад баримт

9.Улсын бүртгэлийн гэрчилгээ (эх хувь)

тийм	үгүй
------	------

Улс төрийн намын буртгэл
хөтлөх журмын хавсралт №7

УЛС ТӨРИЙН НАМЫН НЭР БАТАЛГААЖУУЛАЛТ

Он, сар, өдөр:

Байгууллагын нэр: Улсын дээд шүүх

Намын нэр	
Хүсэлт гаргагчийн Эцэг /эх/-ийн нэр	
Хүсэлт гаргагчийн нэр	
Хүсэлт гаргагчийн регистрийн дугаар	

Баталгаажуулсан:

Дарга _____ / /
/Тамга/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

НЭР БАТАЛГААЖУУЛАЛТЫГ СУНГАСАН ТЭМДЭГЛЭЛ

Сунгалт хийсэн он, сар, өдөр:

Хүчинтэй он, сар, өдөр:

Хүсэлт гаргагчийн	Эцэг /эх/-ийн нэр	
	Өөрийн нэр	
	Регистрийн дугаар	

Баталгаажуулсан:

Дарга _____ / /
/Тамга/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

**Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №8**



**ТАМГА, ТЭМДГИЙН ХЯНАЛТЫН ДУГААР ШИНЭЭР
БОЛОН ДАХИН АВАХ ӨРГӨДӨЛ**

... он ... сар ... өдөр

1. Намын нэр:

2. Намын регистрацийн дугаар:

--	--	--	--	--	--	--

3. Хяналтын дугаар шинээр авах үндэслэл:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

4. Өргөдөл гаргагчийн мэдээлэл:

Овог:

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:

Регистрийн дугаар:

Утасны дугаар:

Намд эрхэлж буй ажил:

.....
.....
.....
.....
.....
.....
.....

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №8А

НАМЫН ТАМГАНЫ ДУГААР ШИНЭЭР АВАХ БОЛОН
ДАХИН АВАХ ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТ

1.Өргөдөл:

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

3.Намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн мэдээлэл
(овог, нэр, албан тушаал, иргэний үнэмлэхийн хуулбар, итгэмжлэл)

Хүсэлтэд хавсаргах баримт бичгүүд:

4.тамганы дугаар шинээр авах болсон үндэслэл

5.тамга ашиглах боломжгүй элэгдэж хуучирсан, гэмтсэн, устсан, өнгө, загвар,
бэлэг тэмдэг, хэлбэрийг өөрчлүүлэх болон хаяж үрэгдүүлсэн аль нь болох,
түүнийг нотолсон баримт

ТАМГА, ТЭМДГИЙН ХЯНАЛТЫН ДУГААР ОЛГОХ
БҮРТГЭЛИЙН ХУУДАС

... он ... сар ... өдөр

1. Намын нэр:

2. Намын регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--

3. Тамга, тэмдгийн хяналтын дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

4. Хяналтын дугаар олгох үндэслэл:

Шинээр олгосон

/гэмтээсэн, устсан, оноосон нэр өөрчилсөн, өөрчлөн
байгуулагдсан, үрэгдүүлсэн, хүчингүй болгосон/

Дахин олгосон

/аль тохигох нүдэнд √ тэмдэглэгээ хийнэ/

/доогуур зурж тэмдэглэнэ/

ДАРГА

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

ТАМГА, ТЭМДГИЙН ҮЙЛДВЭРЭЭС УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД
БУЦААХ /ТАЙЛАГНАХ/ ХЭСЭГ

1. Намын нэр:

.....

2. Намын регистрийн дугаар:

.....

3. Тамга, тэмдгийн өнгө, загвар:

.....

4. Тамга, тэмдэг захиалсан этгээдийн эцэг /эх/-ийн нэр,
өөрийн нэр, утасны дугаар:

5. Тамга, тэмдэг үйлдвэрлэсэн хуулийн этгээдийн нэр:

.....

6. Тамга, тэмдэг үйлдвэрлэсэн он, сар, өдөр:

Үйлдвэрлэгчийн гарын үсэг:

/Гарын үсэг, тэмдэг/

Тамга, тэмдгийн
дардас

/_____ /

/Гарын үсгийн тайлал/

Улс төрийн намын бүртгэл
хөтлөх журмын хавсралт №10

**НАМЫН ОРШИН БАЙГАА ГАЗРЫН ХЯАГ ӨӨРЧЛӨГДСӨНИЙГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

1. Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--	--

2. Намын бүтэн болон товчилсон нэр:

[]

3. Намын оршин байгаа газрын хаяг өөрчлөгдсөнийг бүртгүүлэх тухай өргөдөл:

[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]
[.....]

4. Өргөдөл гаргагчийн мэдээлэл:

Овог:

[]

Эцэг /эх/-ийн нэр:

[]

Өөрийн нэр:

[]

Регистрийн дугаар:

[]

Утасны дугаар:

[]

Намд эрхэлж буй ажил:

[]

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

НАМЫН ОРШИН БАЙГАА ГАЗРЫН ХАЯГ ӨӨРЧЛӨГДСӨНИЙГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТ

1.Өргөдөл:

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

3.Намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн мэдээлэл.
(овог, нэр, албан тушаал, иргэний үнэмлэхийн хуулбар, итгэмжлэл)

Хүсэлтэд хавсаргах баримт бичгүүд:

4.намын өмнөх хаяг

5.намын шинэ хаяг

6.шинэ хаягийн оршин суугаа газрын тодорхойлолт, лавлагаа, эрх бүхий
этгээдтэй байгуулсан гэрээ, түрээсээр ашиглаж байгаа бол түрээсийн гэрээ,
уг гэрээг намын эрх бүхий этгээд байгуулсан тухай нотлох баримт

**ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ
БҮРТГЭЛ ХИЙЛГЭХ ӨРГӨДӨЛ**

1.Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--	--

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

[Large rectangular box for handwriting]

3.Намын хөрөнгө, түүний өөрчлөлттэй холбоотой өргөдөл:

[Large rectangular box with horizontal dotted lines for handwriting]

4.Өргөдөл гаргагчийн мэдээлэл:

Овог:

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:

Регистрийн дугаар:

Утасны дугаар:

Намд эрхэлж буй ажил:

[Large rectangular box with horizontal lines for handwriting]

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХӨЛБООТОЙ
БҮРТГЭЛ ХИЙЛГЭХ ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТ

1.Өргөдөл гаргасан он, сар өдөр:

--	--	--	--	--	--	--	--	--

2.Намын бүтэн болон товчилсон нэр:

3.Намын дарга эсхүл түүнээс олгосон итгэмжлэл

4.Өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл

5.Хөрөнгөд өөрчлөлт оруулах болсон үндэслэл шалтгаан, холбогдох баримт

6.Өөрчлөлт оруулсан шийдвэр, хурлын тэмдэглэл

7.Хуралд оролцсон гишүүдийн бүртгэл, утасны дугаар, хурлыг цахимаар хийсэн бол хурлын явцыг баталгаажуулсан баримт, санал хураалтын дүнг баталгаажуулсан баримт, холбогдох бусад баримт.

8.Өөрчлөлт орохоос өмнөх, өөрчлөлт орсны дараах мэдээлэл